

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2023/70/НА-СТА-ТӨА

|                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|-----------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Цахим хуудас:<br><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Улаанбаатар хот<br>2023 он | Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас:261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a><br><br>Аудитын менежер: С.Нацагдорж<br>Утас:261885 Цахим хаяг: <a href="mailto:natsagdorjs@audit.gov.mn">natsagdorjs@audit.gov.mn</a><br><br>Аудитор: М.Лхагвасүрэн<br>Утас: 260512 Цахим хаяг: <a href="mailto:lkhagvasuren@audit.gov.mn">lkhagvasuren@audit.gov.mn</a><br><br>Гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Мүүрь Аудит ХХК-ийн захирал У.Оюунаа<br>Утас:976-7015 0003 Цахим хаяг: <a href="mailto:Info@moore-mongolia.mn">Info@moore-mongolia.mn</a> |
|-----------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

|                                                                            |    |
|----------------------------------------------------------------------------|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....                                       | 2  |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....                                     | 5  |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....                                    | 11 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН.....                                                     | 17 |
| 4.1 Ерөнхий зүйл .....                                                     | 17 |
| 4.2 Материаллаг байдал.....                                                | 17 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....                        | 17 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... | 17 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....               | 18 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....                              | 19 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....                                                  | 20 |
| 5.1 Төлбөрийн акт .....                                                    | 20 |
| 5.2 Албан шаардлага .....                                                  | 20 |
| 5.3 Зөвлөмж.....                                                           | 21 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....                        | 24 |

### Товчилсон үгийн жагсаалт

|         |                                               |
|---------|-----------------------------------------------|
| АДБОУС  | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТОУС   | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт    |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль  |
| ТӨБЗГ   | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар     |
| ТУЗ     | Төлөөлөн удирдах зөвлөл                       |
| ХХК     | Хязгаарлагдмал хариуцлагатай компани          |



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ С.НАРАНЦОГТ ТАНАА

2023.03.15 № 04/1579

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Эрдэнэс Монгол ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 19,138.7 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Эрдэнэс Монгол ХХК нь 2020 оны цэвэр ашгийн дүнгээс улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны 766.7 сая төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Төсөл хөтөлбөр, охин хараат компанид оруулсан 5,451.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтад үнэ цэний бууралт үүссэн боловч бүртгэлд тусгаагүй;
- Монголбанканд төлөх Эрдэнэс-1 бондын өр төлбөр нь Монголбанкны арилжааны банкуудаас худалдан авсан гэрээний үүргээс нэрлэсэн үнээр 88.0 сая төгрөгийн зөрүүтэй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 23 дугаар зүйлийн 23.5.1 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

## **Асуудлыг онцолсон хэсэг**

Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 147 дугаар тогтоолоор давуу эрхийн хувьцааг 5.0 сая ширхэг болгон нэмэгдүүлсэн бөгөөд уг давуу эрхийн хувьцааны өөрчлөлтийг дүрэмд тусгаж, хувьцааг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд хадгалуулсан байна. Монгол улсын иргэн бүрд эзэмшүүлэх нэг ширхэг давуу эрхийн хувьцаа нь худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах эрхгүй, өв залгамжлагдахгүй болно.

Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 225 дугаар тогтоолоор Үндэсний баялгийн сан бий болгох бэлтгэл хангах зорилгоор "Эрдэнэс Монгол" ХХК-ийн охин, хараат компани болон харьяа бусад хуулийн этгээдийг нэгдлийн хэмжээнд нүүрс, эрчим хүчний болон зэс, металлын гэсэн үйл ажиллагааны чиглэлээр бүлэглэж, группийн зарчмаар ажиллуулахаар тогтож, Эрдэнэт үйлдвэр, Монголросцветмет төрийн өмчит үйлдвэрийн газруудыг Эрдэнэс Монгол нэгдлийн харьяанд ажиллуулахаар тогтоосон байна.

## **Аудитын гол асуудал**

Тайлант онд орлогыг 172,821.3 сая төгрөгөөр, зардлыг 48,798.4 сая төгрөг, ашгийг 124,022.9 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр 184,763.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 38,575.5 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, гадаад валютын ханшийн өсөлтөөс 5,185.6 сая төгрөгийн алдагдал хүлээж, 135,480.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 10 чиглэлд 66 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар   | Үзүүлэлт                                | 2021 оны 12-р сарын 31       | 2022 оны 12-р сарын 31       |
|-----------------|-----------------------------------------|------------------------------|------------------------------|
| <b>1</b>        | <b>ХӨРӨНГӨ</b>                          |                              |                              |
| <b>1.1</b>      | <b>Эргэлтийн хөрөнгө</b>                |                              |                              |
| 1.1.1           | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө         | 815,378,166.85               | 24,745,151,989.63            |
| 1.1.2           | Дансны авлага                           | 1,518,182,329.36             | 13,380,544,607.62            |
| 1.1.3           | Татвар, НДШ – ийн авлага                | 476,948,068.73               | 1,036,904,658.09             |
| 1.1.4           | Бусад авлага                            | 12,901,377,578.57            | 11,339,729,010.62            |
| 1.1.6           | Бараа материал                          | 45,264,342.20                | 48,771,795.08                |
| 1.1.7           | Урьдчилж төлсөн зардал/тооцоо           | 316,372,622.56               | 164,781,814.13               |
| <b>1.1.11</b>   | <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>          | <b>16,073,523,108.27</b>     | <b>50,715,883,875.17</b>     |
| <b>1.2</b>      | <b>Эргэлтийн бус хөрөнгө</b>            |                              |                              |
| 1.2.1           | Үндсэн хөрөнгө                          | 166,581,976,925.43           | 137,260,392,169.82           |
| 1.2.2           | Биет бус хөрөнгө                        | 528,978,754.92               | 37,585,930.88                |
| 1.2.4           | Урт хугацаат хөрөнгө оруулалт           | 9,128,897,051,467.00         | 9,150,284,363,943.16         |
| 1.2.5           | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө           | 1,776,731,862.86             | -                            |
| 1.2.6           | Хойшлогдсон татварын хөрөнгө            | 8,598,656,617.61             | 11,873,593,356.78            |
| 1.2.8           | Бусад эргэлтийн бус хөрөнгө             | 864,064,607,998.38           | 918,223,481,517.03           |
| <b>1.2.10</b>   | <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>      | <b>10,170,448,003,626.20</b> | <b>10,217,679,416,917.69</b> |
| <b>1.3</b>      | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>               | <b>10,186,521,526,734.47</b> | <b>10,268,395,300,792.86</b> |
| <b>2</b>        | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>          |                              |                              |
| <b>2.1</b>      | <b>Өр төлбөр</b>                        |                              |                              |
| <b>2.1.1</b>    | <b>Богино хугацаат өр төлбөр</b>        |                              |                              |
| 2.1.1.1         | Дансны өглөг                            | 9,841,718,815.10             | 145,215,565.59               |
| 2.1.1.2         | Цалингийн өглөг                         | 902,886.35                   | 5,871,916.48                 |
| 2.1.1.3         | Татварын өр                             | 3,147,326,205.98             | 9,531,835,187.13             |
| 2.1.1.5         | Богино хугацаат зээл                    | <b>19,601,008,942.90</b>     | 1,016,430,397.90             |
| 2.1.1.6         | Хүүгийн өглөг                           | <b>8,774,687,604.28</b>      | 1,060,085,418.25             |
| 2.1.1.8         | Урьдчилж орсон орлого                   | 14,700,631.72                | -                            |
| 2.1.1.10        | Бусад богино хугацаат өр төлбөр         | 1,479,692,518.34             | 280,415,747.22               |
| <b>2.1.1.13</b> | <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b> | <b>42,860,037,604.67</b>     | <b>12,039,854,232.57</b>     |
| <b>2.1.2</b>    | <b>Урт хугацаат өр төлбөр</b>           |                              |                              |
| 2.1.2.1         | Урт хугацаат зээл                       | 147,921,240,525.60           | 72,397,933,934.30            |
| 2.1.2.4         | Бусад урт хугацаат өр төлбөр            | 858,139,991,926.97           | 905,212,647,479.76           |
| <b>2.1.2.6</b>  | <b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>    | <b>1,006,061,232,452.57</b>  | <b>977,610,581,414.06</b>    |
| <b>2.2</b>      | <b>Өр төлбөрийн нийт дүн</b>            | <b>1,048,921,270,057.24</b>  | <b>989,650,435,646.63</b>    |
| <b>2.3</b>      | <b>Эздийн өмч</b>                       |                              |                              |
| 2.3.1           | Өмч: - төрийн                           | 100,000,000.00               | 100,000,000.00               |
| 2.3.2           | - хувийн                                | 3,000,000.00                 | 5,000,000.00                 |
| 2.3.6           | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл     | 17,175,601,462.26            | 1,498,619,291.40             |
| 2.3.8           | Эздийн өмчийн бусад хэсэг               | 9,128,284,251,467.00         | 9,149,637,563,943.16         |
| 2.3.9           | Хуримтлагдсан ашиг                      | (7,962,596,252.03)           | 127,503,681,911.67           |
| <b>2.3.11</b>   | <b>Эздийн өмчийн дүн</b>                | <b>9,137,600,256,677.23</b>  | <b>9,278,744,865,146.23</b>  |
| <b>2.4</b>      | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>   | <b>10,186,521,526,734.47</b> | <b>10,268,395,300,792.86</b> |

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт                                                         | 2021 оны 12-р сарын 31     | 2022 оны 12-р сарын 31    |
|---------------|------------------------------------------------------------------|----------------------------|---------------------------|
| 1             | <b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>                               | 26,291,787,091.91          | 64,371,595,879.32         |
| 2             | Борлуулалтын өртөг                                               | 23,809,108,549.30          | 19,953,900,900.77         |
| 3             | <b>Нийт ашиг (алдагдал)</b>                                      | <b>2,482,678,542.61</b>    | <b>44,417,694,978.55</b>  |
| 4             | Түрээсийн орлого                                                 | -                          | -                         |
| 5             | Хүүгийн орлого                                                   | 3,026,691,867.46           | 3,044,391,025.44          |
| 6             | Ногдол ашгийн орлого                                             | -                          | 117,200,000,000.00        |
| 7             | Эрхийн шимтгэлийн орлого                                         | -                          | -                         |
| 8             | Бусад орлого                                                     | 162,459,245.13             | 147,641,051.91            |
| 9             | Борлуулалт, маркетингийн зардал                                  | -                          | -                         |
| 10            | Ерөнхий ба удирдлагын зардал                                     | 6,002,687,298.45           | 5,145,998,503.52          |
| 11            | Санхүүгийн зардал                                                | 21,049,790,262.48          | 12,328,559,936.69         |
| 12            | Бусад зардал                                                     | 339,751,866.88             | 1,284,305,281.75          |
| 13            | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)                       | 118,293,873.39             | (5,185,626,397.27)        |
| 14            | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)                       | -                          | (440,706,439.30)          |
| 15            | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)                     | -                          | -                         |
| 16            | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)                  | -                          | -                         |
| 17            | Бусад ашиг (алдагдал)                                            | -                          | -                         |
| 18            | <b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>                     | <b>(21,602,105,899.22)</b> | <b>140,424,530,497.37</b> |
| 19            | Орлогын татварын зардал                                          | (1,455,702,750.74)         | 4,944,291,503.63          |
| 20            | <b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>                           | <b>(20,146,403,148.48)</b> | <b>135,480,238,993.74</b> |
| 21            | <b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b> |                            |                           |
| 22            | <b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>                       | <b>(20,146,403,148.48)</b> | <b>135,480,238,993.74</b> |
| 23            | <b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>                                  | -                          | -                         |
|               | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү                      | -                          | -                         |
|               | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү                               | -                          | -                         |
|               | Бусад олз (гарз)                                                 | -                          | -                         |
| 24            | <b>Орлогын нийт дүн</b>                                          | <b>29,480,938,204.50</b>   | <b>184,763,627,956.67</b> |
| 25            | <b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>               | <b>(20,146,403,148.48)</b> | <b>135,480,238,993.74</b> |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт                                                                                 | Өмч                   | Хөрөнгийн дахин<br>үнэлгээний<br>нэмэгдэл | Эздийн өмчийн<br>бусад хэсэг | Хуримтлагдсан<br>ашиг     | Нийт дүн                    |
|------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-------------------------------------------|------------------------------|---------------------------|-----------------------------|
| <b>2020 оны 12 -р<br/>сарын 31 -ний<br/>үлдэгдэл</b>                                     | <b>103,000,000.00</b> | <b>17,175,601,462.26</b>                  | <b>9,128,284,251,467.00</b>  | <b>12,186,806,896.42</b>  | <b>9,157,749,659,825.68</b> |
| Нягтлан бодох<br>бүртгэлийн<br>бодлогын<br>өөрчлөлтийн<br>нөлөө,<br>алдааны<br>залруулга | -                     | -                                         | -                            | (3,000,000.00)            | (3,000,000.00)              |
| Залруулсан<br>үлдэгдэл                                                                   | 103,000,000.00        | 17,175,601,462.26                         | 9,128,284,251,467.00         | 12,183,806,896.42         | <b>9,157,746,659,825.68</b> |
| Тайлант үеийн<br>цэвэр ашиг<br>(алдагдал)                                                | -                     | -                                         | -                            | (20,146,403,148.45)       | <b>(20,146,403,148.45)</b>  |
| <b>2021 оны 12 -р<br/>сарын 31 -ний<br/>үлдэгдэл</b>                                     | <b>103,000,000.00</b> | <b>17,175,601,462.26</b>                  | <b>9,128,284,251,467.00</b>  | <b>(7,962,596,252.03)</b> | <b>9,137,600,256,677.23</b> |
| Нягтлан бодох<br>бүртгэлийн<br>бодлогын<br>өөрчлөлтийн<br>нөлөө,<br>алдааны<br>залруулга | -                     | (15,676,982,170.86)                       | -                            | (13,140,830.04)           | <b>(15,690,123,000.90)</b>  |
| Залруулсан<br>үлдэгдэл                                                                   | 103,000,000.00        | 1,498,619,291.40                          | 9,128,284,251,467.00         | (7,975,737,082.07)        | <b>9,121,910,133,676.33</b> |
| Тайлант үеийн<br>цэвэр ашиг<br>(алдагдал)                                                | -                     | -                                         | -                            | 135,480,238,993.74        | <b>135,480,238,993.74</b>   |
| Өмчид гарсан<br>өөрчлөлт                                                                 | 2,000,000.00          | -                                         | 21,353,312,476.16            | -                         | <b>21,355,312,476.16</b>    |
| Зарласан<br>ногдол ашиг                                                                  | -                     | -                                         | -                            | (820,000.00)              | <b>(820,000.00)</b>         |
| <b>2022 оны 12 -р<br/>сарын 31 -ний<br/>үлдэгдэл</b>                                     | <b>105,000,000.00</b> | <b>1,498,619,291.40</b>                   | <b>9,149,637,563,943.16</b>  | <b>127,503,681,911.67</b> | <b>9,278,744,865,146.23</b> |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт                                                              | 2021 оны 12-р сарын 31      | 2022 оны 12-р сарын 31     |
|---------------|-----------------------------------------------------------------------|-----------------------------|----------------------------|
| <b>1</b>      | <b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>                          |                             |                            |
| <b>1.1</b>    | <b>Мөнгөн орлогын дүн (+)</b>                                         | <b>36,498,734,932.53</b>    | <b>55,421,834,738.71</b>   |
| 1.1.1         | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого                          | 36,462,674,689.53           | 55,409,724,991.63          |
| 1.1.2         | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө                                | 801,000.00                  | 9,276,773.08               |
| 1.1.3         | Бусад мөнгөн орлого                                                   | 35,259,243.00               | 2,832,974.00               |
| <b>1.2</b>    | <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>                                        | <b>252,051,300,677.63</b>   | <b>48,856,668,249.59</b>   |
| 1.2.1         | Ажиллагчдад төлсөн                                                    | 2,891,604,341.47            | 2,498,817,454.54           |
| 1.2.2         | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн                                | 827,115,480.25              | 624,547,506.08             |
| 1.2.3         | Бараа материал худалдан авахад төлсөн                                 | 40,978,561.60               | 75,436,863.00              |
| 1.2.4         | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн                 | 108,638,552.40              | 25,626,265.00              |
| 1.2.5         | Хүүгийн төлбөрт төлсөн                                                | 5,800,713,780.13            | 20,389,805,858.94          |
| 1.2.6         | Татварын байгууллагад төлсөн                                          | 7,406,047,340.44            | 7,751,432,271.66           |
| 1.2.7         | Даатгалын төлбөрт төлсөн мөнгө                                        | -                           | 132,089,767.27             |
| 1.2.8         | Бусад мөнгөн зарлага                                                  | 234,976,202,621.34          | 17,358,912,263.10          |
| <b>1.3</b>    | <b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>             | <b>(215,552,565,745.10)</b> | <b>6,565,166,489.12</b>    |
| <b>2</b>      | <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>              |                             |                            |
| <b>2.1</b>    | <b>Мөнгөн орлогын дүн (+)</b>                                         | <b>217,489,018,330.01</b>   | <b>120,648,811,772.59</b>  |
| 2.1.1         | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого                          | 1,500,000,000.00            | -                          |
| 2.1.2         | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт                | 215,976,349,736.99          | 2,879,461,772.59           |
| 2.1.3         | Хүлээн авсан ногдол ашиг                                              | -                           | 117,200,000,000.00         |
| 2.1.4         | Хүлээн авсан хүүгийн орлого                                           | 12,668,593.02               | 569,350,000.00             |
| <b>2.2</b>    | <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>                                        | <b>271,675,461.00</b>       | <b>13,774,743,868.49</b>   |
| 2.2.1         | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                                   | 209,171,535.00              | 449,915,690.91             |
| 2.2.2         | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                                 | 62,503,926.00               | 4,038,700.00               |
| 2.2.3         | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа                                | -                           | 13,320,789,477.58          |
| <b>2.3</b>    | <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b> | <b>217,217,342,869.01</b>   | <b>106,874,067,904.10</b>  |
| <b>3</b>      | <b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>                      |                             |                            |
| <b>3.1</b>    | <b>Мөнгөн орлогын дүн (+)</b>                                         | <b>514,495.29</b>           | <b>12,893,537,356.08</b>   |
| 3.1.1         | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан                   | -                           | 12,881,900,360.27          |
| 3.1.2         | Бусад                                                                 | 514,495.29                  | 11,636,995.81              |
| <b>3.2</b>    | <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>                                        | <b>8,467,794,430.68</b>     | <b>102,402,997,926.51</b>  |
| 3.2.1         | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө                          | 8,467,073,946.68            | 102,399,933,148.77         |
| 3.2.2         | Төлсөн ногдол ашиг                                                    | -                           | 820,000.00                 |
| 3.2.3         | Бусад                                                                 | 720,484.00                  | 2,244,777.74               |
| <b>3.3</b>    | <b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>         | <b>(8,467,279,935.39)</b>   | <b>(89,509,460,570.43)</b> |
| <b>4</b>      | <b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>                                       | <b>(6,802,502,811.48)</b>   | <b>23,929,773,822.78</b>   |
| 5             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                      | 7,617,880,978.34            | 815,378,166.85             |
| 6             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                     | 815,378,166.85              | 24,745,151,989.63          |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| №                                               | Үндсэн үзүүлэлтүүд                                | Хэмжих нэгж | 2021 оны гүйцэтгэл | 2022 он          |               |                   |                 |
|-------------------------------------------------|---------------------------------------------------|-------------|--------------------|------------------|---------------|-------------------|-----------------|
|                                                 |                                                   |             |                    | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл     | Хэтрэлт (хэмнэлт) | Биелэлтийн хувь |
| Нэг. Нийт орлого                                |                                                   | Мян.төг     | 31,236,286.9       | 172,821,322.7    | 184,763,628.0 | 11,942,305.2      | 106.9           |
| 1.1                                             | Замын хураамжийн орлого                           | Мян.төг     | 23,997,909.0       | 46,467,066.4     | 61,190,653.7  | 14,723,587.3      | 131.7           |
| 1.2                                             | Менежментийн төлбөр                               | Мян.төг     | 2,067,887.1        | 5,641,243.9      | 2,955,492.1   | (2,685,751.7)     | 52.4            |
| 1.3                                             | Шивээ Овоо талбай ашигласны төлбөр                | Мян.төг     | 224,400.0          | 224,400.0        | 224,400.0     | -                 | -               |
| 1.4                                             | Бусад орлого                                      | Мян.төг     | 1,919,398.9        | 117,169,829.6    | 117,348,691.1 | 178,861.4         | 100.2           |
| 1.5                                             | Хүүгийн орлого                                    | Мян.төг     | 3,026,691.9        | 3,318,782.8      | 3,044,391.0   | (274,391.8)       | 91.7            |
| Хоёр. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ү/а зардал       |                                                   | Мян.төг     | 51,188,402.3       | 48,037,000.0     | 38,575,639.4  | (9,461,360.6)     | 80.             |
| А. Гашуунсухайтын автозамын зардал              |                                                   | Мян.төг     | 23,576,915.7       | 19,771,512.7     | 17,163,745.5  | (2,607,767.2)     | 86.8            |
| 2.1                                             | Зээлийн хүүгийн зардал                            | Мян.төг     | 13,797,543.6       | 11,789,768.8     | 11,592,866.4  | (196,902.5)       | 98.3            |
| 2.2                                             | "ГСАЗ" ХХК-ийн гэрээний дагуу зардал              | Мян.төг     | 5,743,373.2        | 6,869,925.4      | 4,865,313.5   | (2,004,612.0)     | 70.8            |
| 2.3                                             | Гашуунсухайт автозамын гэрээт цагдаагийн зардал   | Мян.төг     | 1,069,756.5        | 1,111,818.4      | 705,565.7     | (406,252.7)       | 63.5            |
| 2.4                                             | Гашуун сухайт автозамын их засварын урсгал зардал | Мян.төг     | 2,966,242.4        | -                | -             | -                 | -               |
| Б.Эрдэнэс Монгол ХХК-ийн үйл ажиллагааны зардал |                                                   | Мян.төг     | 20,105,351.6       | 27,156,015.3     | 20,314,455.7  | (6,841,559.7)     | 74.8            |
| 2.5                                             | Цалингийн зардал                                  | Мян.төг     | 3,157,148.0        | 3,226,949.4      | 2,661,050.4   | (565,899.0)       | 82.5            |
| 2.6                                             | Нийгмийн даатгалын шимтгэл                        | Мян.төг     | 417,398.7          | 435,638.2        | 319,660.2     | (115,978.0)       | 73.4            |
| 2.7                                             | ТУЗ-ийн зардал                                    | Мян.төг     | 180,973.6          | 311,769.6        | 183,129.5     | (128,640.1)       | 58.7            |
| 2.8                                             | ТУЗ-ийн дэргэдэх хяналтын нэгж                    | Мян.төг     | 175,560.8          | 338,894.4        | 171,248.1     | (167,646.3)       | 50.5            |
| 2.9                                             | Оффисын зардал                                    | Мян.төг     | 673,685.2          | 790,273.7        | 677,277.5     | (112,996.3)       | 85.7            |
|                                                 | Оффисын түрээс                                    | Мян.төг     | 644,230.7          | 727,653.7        | 644,230.7     | (83,423.1)        | 88.5            |
|                                                 | Оффисын засвар                                    | Мян.төг     | -                  | 30,220.0         | 2,675.6       | (27,544.4)        | 8.9             |
|                                                 | Харуул хамгаалалт                                 | Мян.төг     | 29,454.5           | 32,400.0         | 30,371.2      | (2,028.8)         | 93.7            |
| 2.10                                            | Бичиг хэрэг                                       | Мян.төг     | 38,049.7           | 47,521.2         | 41,512.7      | (6,008.5)         | 87.4            |
| 2.11                                            | Хангамжийн материал                               | Мян.төг     | 31,390.9           | 47,723.2         | 23,305.5      | (24,417.7)        | 48.8            |
| 2.12                                            | Хурал зөвлөгөөн, уулзалтын зардал                 | Мян.төг     | 2,832.4            | 60,000.0         | 7,473.5       | (52,526.5)        | 12.5            |
| 2.13                                            | Мэдээлэл, зар сурталчилгаа                        | Мян.төг     | 165,581.6          | 138,600.0        | 71,545.0      | (67,055.0)        | 51.6            |
| 2.14                                            | Гадаад албан томилолт                             | Мян.төг     | -                  | 80,000.0         | 79,180.2      | (819.8)           | 99.0            |
| 2.15                                            | Дотоод албан томилолт                             | Мян.төг     | 16,901.8           | 86,992.0         | 22,220.1      | (64,771.9)        | 25.5            |
| 2.16                                            | Гэрээт ажил                                       | Мян.төг     | 150,816.4          | 639,500.0        | 78,775.7      | (560,724.3)       | 12.3            |
| 2.17                                            | Авто машинтай холбоотой зардал                    | Мян.төг     | 82,742.3           | 163,738.6        | 58,475.5      | (105,263.2)       | 35.7            |
|                                                 | Автын сэлбэг,засвар үйлчилгээ                     | Мян.төг     | 55,317.5           | 60,200.0         | 29,406.6      | (30,793.4)        | 48.8            |
|                                                 | Шатахуун, шатах тослох материал                   | Мян.төг     | 8,518.2            | 56,050.0         | 836.4         | (55,213.6)        | 1.5             |
|                                                 | Авто машины даатгалын зардал                      | Мян.төг     | 18,906.6           | 47,488.6         | 28,232.5      | (19,256.2)        | 59.5            |
| 2.18                                            | Сургалтын зардал                                  | Мян.төг     | 6,308.5            | 85,303.6         | 20,690.3      | (64,613.3)        | 24.3            |
| 2.19                                            | Авлигын тухай сурталчлан таниулах зардал          | Мян.төг     | -                  | 5,000.0          | -             | (5,000.0)         | -               |
| 2.20                                            | Шуудан, харилцаа холбоо                           | Мян.төг     | 40,467.0           | 70,052.6         | 26,698.4      | (43,354.2)        | 38.1            |
| 2.21                                            | Ном, хэвлэл захиалга                              | Мян.төг     | 4,810.1            | 2,000.0          | 1,329.1       | (670.9)           | 66.5            |
| 2.22                                            | Тайлан үйлчилгээний зардал                        | Мян.төг     | -                  | 25,000.0         | -             | (25,000.0)        | -               |
| 2.23                                            | Нийгмийн арга хэмжээний зардал                    | Мян.төг     | 88,832.7           | 203,000.0        | 234,885.2     | 31,885.2          | 115.7           |
| 2.24                                            | Элэгдлийн зардал                                  | Мян.төг     | 14,366,840.1       | 18,039,288.9     | 14,670,955.4  | (3,368,333.5)     | 81.3            |
| 2.27                                            | Татвар, төлбөр, шимтгэл,хураамж, даатгал          | Мян.төг     | 48,951.8           | 1,310,405.9      | 39,289.1      | (1,271,116.8)     | 3.0             |
| 2.28                                            | Аудитын төлбөр                                    | Мян.төг     | 320,121.0          | 970,000.0        | 36,545.5      | (933,454.5)       | 3.8             |
| 2.29                                            | Үйлчилгээний эрх                                  | Мян.төг     | 35,989.0           | 58,364.0         | 44,702.4      | (13,661.6)        | 76.6            |
| 2.30                                            | Баялгийн сан болон, стратегийн шилжилтийн зардал  | Мян.төг     | 99,950.0           | -                | -             | -                 | -               |
| 2.31                                            | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал    | Мян.төг     | -                  | 20,000.0         | -             | (20,000.0)        | -               |
| 2.32                                            | Лицензийн зардал                                  | Мян.төг     | -                  | -                | 420,880.8     | 420,880.8         | -               |
| 2.33                                            | Хайгуул үнэлгээний зардал                         | Мян.төг     | -                  | -                | 423,625.6     | 423,625.6         | -               |
| Б. Нэмэлт зардал                                |                                                   | Мян.төг     | 7,506,135.1        | 1,109,471.9      | 1,097,438.2   | (12,033.8)        | 82.5            |
| 2.34                                            | АХБ-ны төслийн дотоод санхүүжилтийн зардал        | Мян.төг     | 20,200.0           | -                | -             | -                 | -               |

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

|                                              |                                                             |         |                       |                      |                      |                      |             |
|----------------------------------------------|-------------------------------------------------------------|---------|-----------------------|----------------------|----------------------|----------------------|-------------|
| 2.35                                         | АХБ-ны зээлийн шимтгэл, хүүгийн зардал                      | Мян.төг | 290,450.4             | 1,109,471.9          | 1,097,438.2          | (12,033.8)           | 98.9        |
| 2.36                                         | АХБ-ны зээлийн батлан даалтын төлбөр                        | Мян.төг | 7,195,484.6           | -                    | -                    | -                    | -           |
| <b>Гурав. Бусад ашиг (алдагдал)</b>          |                                                             | Мян.төг | <b>105,358.2</b>      | <b>-</b>             | <b>(5,763,458.1)</b> | <b>(5,763,458.1)</b> | <b>82.5</b> |
| 3.1                                          | Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)                 | Мян.төг | 118,293.9             | -                    | (5,185,626.4)        | (5,185,626.4)        | -           |
| 3.2                                          | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)                  | Мян.төг | -                     | -                    | (440,706.4)          | (440,706.4)          | -           |
| 3.3                                          | Бусад ашиг (алдагдал)                                       | Мян.төг | (12,935.6)            | -                    | (137,125.3)          | (137,125.3)          | -           |
| <b>Дөрөв. Татварын өмнөх ашиг (алдагдал)</b> |                                                             | Мян.төг | <b>(19,846,757.2)</b> | <b>124,784,322.7</b> | <b>140,424,530.5</b> | <b>15,640,207.07</b> | <b>82.5</b> |
| 4.1                                          | Орлогын албан татвар                                        | Мян.төг | 301,403.0             | 761,449.3            | 4,944,291.5          | 4,182,842.2          | 649.3       |
| 4.2                                          | Тайлант үеийн алдагдлаас үүссэн хойшлогдсон татварын орлого | Мян.төг | 1,757,105.8           | -                    | -                    | -                    | -           |
| <b>Тав. Цэвэр ашиг (алдагдал)</b>            |                                                             | Мян.төг | <b>(18,391,054.5)</b> | <b>124,022,873.4</b> | <b>135,480,239.0</b> | <b>11,457,365.6</b>  | <b>82.5</b> |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрдэнэс Монгол ХХК нь толгой компанийн болон охин, хараат компани, харьяа хуулийн этгээд, төслийн нэгжийн хамт (цаашид нэгдэл гэх) стратегийн ач холбогдолтой болон бусад томоохон төрийн өмчийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, үнэ цэн бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нийлүүлэх замаар өгөөжийг өсгөх, Үндэсний баялгийн санг бүрдүүлэн Монгол улсын эдийн засагт хувь нэмэр оруулах зорилготой гэж компанийн дүрэмд тодорхойлжээ.

Компанийн дүрэмд тодорхойлсноор толгой компани нь нэгдлийн бүрэлдэхүүнд хамаарах охин, хараат компани, харьяа хуулийн этгээд, төслийн нэгжийн үнэ цэн, үр дүн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор үйл ажиллагааны чиглэлээр группэд нэгтгэн ажиллуулах ба дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ. Үүнд:

- Ашигт малтмалын судалгаа хийж, нөөц тогтоох болон ордын нөөцийг олборлох, баяжуулах, боловсруулах, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх;
- Эрчим хүчний үйлдвэрлэл;
- Зам, тээвэр, ложистик;
- Менежментийн зөвлөх үйлчилгээ;
- Дотоод гадаад худалдаа болон хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд “Хязгаарлагдмал хариуцлагатай компани” гэсэн статустай байна. Өмчийн бүх энгийн хувьцааг 100% Монгол улсын Засгийн газар эзэмшдэг. Мөн Монгол улсын иргэн бүрд эзэмшүүлэх 5.0 сая ширхэг давуу эрхийн хувьцаатай.

Тайлант онд Эрдэнэс Монгол нэгдлийн хэмжээнд санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг бодлогыг боловсронгуй болгох, уул уурхай, дэд бүтцийн төслүүдийг ач холбогдлын хүрээнд эхлүүлэх, эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсруулах зорилт дэвшүүлэн, үйл ажиллагааны хүрээнд 66 ажил хийхээр төлөвлөн ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эрдэнэс Монгол ХХК-ийг Монгол улсын Засгийн газрын 2006 оны 52 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч Засгийн газар томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.7 дахь заалт “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусвар болгох;” Компанийн удирдлагыг Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор томилж байгаа нь компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.8 дахь заалт “Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;” гэсэн заалтуудтай нийцэж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 0.8 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн

этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр баталсан;
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- ЗГ-ын 2021 оны 388 дугаар “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2022 оны 426 дугаар тогтоол “Эрдэнэс Монгол” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2022 оны 217 дугаар тогтоол “Хуулийн этгээд байгуулах тухай”
- ЗГ-ын 2022 оны 225 дугаар тогтоол “Эрдэнэс Монгол” нэгдлийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөгүй** байна.

Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын албанаас 2022 онд 10 чиглэлд хяналт шалгалтын ажил хийхээр төлөвлөснөөс дийлэнх нь охин болон хараат компаниудад чиглэсэн бөгөөд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавих албан тушаалтны чиг үүргийг гүйцэтгэх захирлын тушаалаар баталж, гүйцэтгэлд Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын алба хяналт тавьж ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын алба нь ерөнхий аудитор, чиглэл хариуцсан 2 аудиторын бүрэлдэхүүнтэй ажилладаг. Тайлант онд компанийн хүний нөөцийн үйл ажиллагаа, бүтэц орон тоонд нийцлийн аудит хийхээр төлөвлөсөн боловч бүтэц орон тооны өөрчлөлт 2 удаа хийгдсэн, оны эхэнд сул зогсолтын горимд байснаас төлөвлөгдсөн ажлууд хийгдээгүй байна.

Дотоод хяналтын ажилтны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын ажилтны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтын ажилтнаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 45 дугаар тогтоолоор баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байсан хэдий ч баталснаас хойш

шинэчлэгдсэн болон өөрчлөгдсөн стандартуудын нэмэлт өөрчлөлтийг тусгаагүй, сайжруулалт хийгээгүй байна.

Тайлант онд компани бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн учир Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сайжруулах, компанийн үйл ажиллагаанд нийцүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний тендер зарласан байна. Сонгон шалгаруулалтад Миндүг аудит ХХК шалгарч, гэрээ байгуулсан боловч одоогийн байдлаар гэрээт ажлыг эхлүүлээгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Эрдэнэс Монгол ХХК нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 81,873.8 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| /мянган төгрөгөөр/                                |                         |                         |                     |
|---------------------------------------------------|-------------------------|-------------------------|---------------------|
| Үзүүлэлт                                          | 2021.12.31              | 2022.12.31              | Өөрчлөлт            |
| Б                                                 | 1                       | 2                       | 3=2-1               |
| Мөнгөн хөрөнгө                                    | 815,378.2               | 24,745,152.0            | 23,929,773.8        |
| Авлага                                            | 14,896,508.0            | 25,757,178.3            | 10,860,670.3        |
| Урьдчилгаа                                        | 316,372.6               | 164,781.8               | (151,590.8)         |
| Бараа материал                                    | 45,264.3                | 48,771.8                | 3,507.5             |
| Үндсэн хөрөнгө                                    | 168,358,708.8           | 137,260,392.2           | (31,098,316.6)      |
| Биет бус хөрөнгө                                  | 528,978.8               | 37,585.9                | (491,392.8)         |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт                     | 9,128,897,051.5         | 9,150,284,363.9         | 21,387,312.4        |
| Хойшлогдсон татварын хөрөнгө                      | 8,598,656.6             | 11,873,593.4            | 3,274,936.8         |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө                       | 864,064,608.0           | 918,223,481.5           | 54,158,873.5        |
| <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>10,186,521,526.7</b> | <b>10,268,395,300.8</b> | <b>81,873,774.1</b> |
| Богино хугацаат өглөг                             | 14,484,341.1            | 9,963,338.4             | (4,521,002.6)       |
| Зээл ба хүүгийн өглөг                             | 176,296,937.1           | 74,474,449.8            | (101,822,487.3)     |
| Урт хугацаат өглөг                                | 858,139,991.9           | 905,212,647.5           | 47,072,655.5        |
| Эздийн өмч                                        | 9,137,600,256.7         | 9,278,744,865.1         | 141,144,608.5       |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>10,186,521,526.7</b> | <b>10,268,395,300.8</b> | <b>81,873,774.1</b> |

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, дансны авлага, үндсэн хөрөнгө, урт хугацаат хөрөнгө оруулалт, зээл, урт хугацаат өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө 24,745.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, 23,929.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь замын хураамжийн орлогын өсөлтөөс шалтгаалсан байна. Мөнгөн хөрөнгө нь хэвийн үйл ажиллагаатай арилжааны банкнуудад тархан байршсан бөгөөд касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 0.01 сая төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл 25,757.2 сая төгрөг болж, 10,860.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны эцсээр Гашуунсухайт Таван толгой чиглэлийн автозамаар нүүрс тээвэрлэлт эрс өссөн учир замын хураамжийн авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ. Авлагын үлдэгдэлд

хугацаандаа байгаа 24,410.6 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 1,346.6 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Үүнээс борлуулалтын авлага 346.6 сая, холбоотой талаас авах 1,000.0 сая төгрөгийн авлага байна.

Дансны авлагын насжилтад суурилан нөөц байгуулах аргаар тооцсон найдваргүй авлагын хасагдуулга 57.9 сая төгрөг байна. Тайлант онд 35.6 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулсан, найдваргүйд тооцсон 39.9 сая төгрөгийн авлагыг барагдуулсан бөгөөд данснаас хассан авлага байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны өөрчлөлт нь дараах шалтгаантай байна. Үүнд: Тайлант онд шинээр 449.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр 32.6 сая төгрөгийн автомашин худалдан борлуулсан, 767,2 сая төгрөгийн автомашиныг балансаас баланст шилжүүлсэн, 843,2 сая төгрөгийн хөрөнгийг ангилал хооронд шилжүүлсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд 14,972.8 сая төгрөгийн элэгдэл байгуулж, хуримтлагдсан элэгдлийг 15,676.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх залруулга хийсэн нь үндсэн хөрөнгийн дансны үнэ буурахад нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дийлэнх хэсгийг ГС - ТТ чиглэлийн 275 км хүнд даацын автозам, зам дагасан хөрөнгө, замын арчлалт, хяналт хэрэгжүүлэхэд ашиглагдаж буй хөрөнгө эзэлж байгаа бөгөөд тайлант онд автозамтай холбоотой их засварын ажлууд хийгээгүй байна.

Тайлант онд охин болон хараат компаниуд дахь урт хугацаат хөрөнгө оруулалт 9,150,284.4 сая төгрөг бүртгэгдсэн бөгөөд тайлант хугацаанд 21,387.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: Засгийн газрын 2022 оны 217 дугаар тогтоолоор ашигт малтмал хайх, ашиглах чиг үүрэг бүхий төрийн өмчийн 34 хувийн оролцоотой Эрдэнэс баянбогд ХХК-ийг үүсгэн байгуулж, 34.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Мөн Засгийн газрын 2022 оны 429 дүгээр тогтоолоор Эрдэнэс Монгол ХХК нь Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр тогтоосон тул эзэмшиж буй хувьцааны дүнгээр хөрөнгө оруулалт, эзэмшигчдийн өмч дансыг 21,353.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

Бусад эргэлтийн бус хөрөнгө 918,223.5 сая төгрөг болж, 54,158.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь охин компаниудаас авах урт хугацаат авлагын өсөлт 7,309.5 сая төгрөг, Эрдэнэс силвер ресурс ХХК-аас авах Эрдэнэс-1 бондын хорогдуулсан өртгөөрх авлагыг 46,849.4 сая төгрөгөөр нэмж тохируулснаас шалтгаалсан байна.

Эрдэнэс Монгол ХХК нь 2019 онд Хөгжлийн банкнаас 157,517.7 сая төгрөгийн зээлийг Гашуунсухайт - Тавантолгой чиглэлийн хүнд даацын тусгай зориулалтын 239 км зам, Гашуунсухайт боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх зориулалт бүхий дэд бүтцийг Эрдэнэс Монгол ХХК шилжүүлсэн авсны төлбөрийг төлөх зориулалттай авч, зээлийг зориулалтын дагуу зарцуулсан ба зээлийн эргэн төлөлт 114,868.1 сая төгрөг, урт зээлийн үлдэгдэл 42,649.6 сая төгрөг, зээлийн хүүгийн өглөг 222.0 сая төгрөг байна.

Тайлант оны эцсээр Хөгжлийн банкны хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй.

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 5 сарын 31-ний өдрийн 220 тогтоолын дагуу Эрдэнэс Таван толгой ХК-ийн 2019 оны төрийн өмчийн ногдол ашгаас 117,200.0 сая төгрөгийг Эрдэнэс Монгол ХХК-д хуваарилсныг Хөгжлийн банкны зээлийн төлбөрт шилжүүлснээр 2025 он хүртэлх зээлийг төлсөн нь зээлийн өр төлбөр буурахад нөлөөлсөн байна.

Тус компани 2016 онд Азийн хөгжлийн банкнаас байгууллагын бүтэц, удирдлагын чадавхыг сайжруулах зориулалт бүхий 9,492.9 мянган ам.долларын зээл авч зарцуулсан. Тайлант оны эцсээрх богино хугацаат зээлийн үлдэгдэл 295.1 мянган ам.доллар буюу 1,016.4 сая төгрөг, урт хугацаат зээлийн үлдэгдэл 8,636.2 ам.доллар буюу 29,748.3 сая төгрөг, зээлийн хүүгийн өглөг 243.3 мянган ам.доллар буюу 838.1 сая төгрөг байна.

Тайлант онд үндсэн зээлээс 223.1 мянган ам.доллар буюу 687.5 сая төгрөг, зээлийн хүүнд 114.2 мянган ам.доллар буюу 356.9 сая төгрөг төлсөн боловч ам.долларын ханш өссөнөөс шалтгаалан 5,648.1 сая төгрөгийн ханшийн зөрүүгийн алдагдал хүлээсэн нь зээлийн төгрөгөөрх үлдэгдэл 26,154.7 сая төгрөгөөс 30.764,7 сая төгрөг болж өсөхөд нөлөөлсөн байна.

2022 оны эхний саруудад Коронавируст халдварт цар тахалтай холбоотойгоор Тавантолгой Гашуунсухайт чиглэлийн нүүрс тээвэрлэлт зогсонги байдалд орж, төлөвлөсөн замын хураамжийн орлого тасалдсан учир зардал, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дутагдлыг нөхөх зорилгоор зайлшгүй шаардлагыг харгалзан ТУЗ-ийн 2022 оны 01 сарын 27-ны 1 дугаар тогтоолын дагуу арилжааны банкнаас зээл авсан. Үүнд: санхүүжилтийн зорилгоор 2022 оны 02 сард Хас банкнаас жилийн 14.4 хувийн хүүтэй, 9 сарын хугацаатай, 2,881.9 сая төгрөгийн зээл авсан. Зээлийг хуваарийн дагуу төлж дууссан ба уг зээлийн хүүд төлсөн 216.4 сая төгрөгийг санхүүгийн зардалд хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн дагуу 2020 онд Эрдэнэс Монгол ХХК нь өөрийн охин компанийн эзэмшлийн Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалан үнэт цаас гаргаж, Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн үүргийг төлөх гэрээг арилжааны банкуудтай байгуулан, нэг бүр нь 1,0 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 929,973 ширхэг 929,973.0 сая төгрөгийн Эрдэнэс-1 бондын өрийг бүртгэсэн. Уг бондыг хорогдуулсан өртгөөр бүртгэдэг бөгөөд тайлант онд 47,849.4 сая төгрөгийн хөнгөлөлтийн тохируулга хийж, урт хугацаат өр төлбөрийг нэмэгдүүлсэн.

Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн 5.4-д “Монголбанк энэ хуулийн 5.1-д заасан үнэт цаасыг Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4 дэх заалтад заасан хэрэгслийг ашиглан худалдан авна” гэж заасны дагуу Монголбанк нь уг бондыг арилжааны банкуудаас худалдан авах үүрэгтэй бөгөөд тайлант оны эцэст 8 арилжааны банкуудаас нийт 929,885 ширхэг, 929,885.0 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий бондыг худалдан авсан байна. Энэ нь Эрдэнэс Монгол ХХК-ийн санхүүгийн тайланд бүртгэсэн бондын өр төлбөрөөс 88.0 сая төгрөгөөр илүү байна.

Арилжааны банкуудтай байгуулсан “Иргэний тэтгэврийн зээлийн төлбөрийг үнэт цаасаар төлөх тухай” гэрээний үүргийг Монголбанк шилжүүлсэн авсан боловч Капитал банкттай байгуулсан 166.0 сая төгрөгийн гэрээний өр төлбөрийг шилжүүлэн аваагүй байна.

Эрдэнэс Монгол ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт борлуулсан бүтээгдэхүүний өртөг, түүний хэмжилт, хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын талаар нарийвчлан заагаагүй байна. Үйл ажиллагааны зардлыг эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийн бууралт үүссэн, дүнг найдвартай хэмжиж болохоор бол тайлант үед хүлээн зөвшөөрсөн орлоготой уялдаатайгаар хүлээн зөвшөөрөх ба төлсөн эсвэл төлөхөөр хүлээгдэж буй мөнгөн болон бусад зүйлсийн бодит үнэ цэнээр хэмжиж, нягтлан бодох бүртгэлд тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд үйл ажиллагааны талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал, санхүүгийн зардал гэж ангилсан байна.

Өмнөх онтой харьцуулахад борлуулсан бүтээгдэхүүний өртөг 3,855.2 сая төгрөг, удирдлагын зардал 856.6 сая төгрөгөөр буурсан нь оны эхэнд нүүрс тээвэрлэлт зогсонги байсан, Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж, зардал хэмнэх бодлого баримталсан зэргээс шалтгаалжээ. Тайлант онд Хөгжлийн банкны хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн зарим хэсгийг хугацаанаас өмнө төлснөөс шалтгаалан хүүгийн зардал өмнөх онтой харьцуулахад 8,721.2 сая төгрөгөөр багассан байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт Гашуунсухайт автозам ХХК-ийн үйл ажиллагааны зардал, гэрээт цагдаагийн төлбөр, зам, зам дагасан хөрөнгийн элэгдлийг хамруулсан байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу хөрөнгө оруулалт болон зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөл 2021 оны 19, 20 дугаар тогтоолоор 2022 оны бизнес төлөвлөгөө, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Дээрх төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2022 оны 32 дугаар тогтоолоор тодотгож, тайлант оны нийт орлогыг 172,821.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 48,798.5 сая төгрөгөөр баталж, 124,022.9 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллахаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 184,763.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 38,575.6 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, бусад зардалд 5,763.5 сая төгрөгийг тооцож, 4,944.3 сая төгрөгийн орлогын албан татвар тайлагнаж, 135,480.2 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 184,763.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 11,942.3 сая төгрөг буюу 6.9 хувиар давсан нь замын хураамжийн орлого өссөнөөс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 38,575.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 9,461.4 сая төгрөг буюу 19.6 хувийн хэмнэсэн гүйцэтгэлтэй байна. Үүнээс 3,368.3 сая төгрөг нь элэгдлийн зөрүүнээс, 6,093.1 сая төгрөг нь зардлын хэмнэлтээс үүссэн байна. Гол хэмнэлтийг дурдвал: Гашуунсухайт авто зам ХХК-д гэрээний дагуу зардалд 6,869.9 сая төгрөг төсөвлөснөөс, гүйцэтгэлээр 4,865.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, 2,004.6 сая төгрөг, цалин нийгмийн даатгалд 4,313.3 сая төгрөг төсөвлөснөөс (ТУЗ, Дотоод аудитын алба багтсан) гүйцэтгэлээр 3,335.1 сая төгрөг зарцуулж, 978,2 сая төгрөг, дотоод томилолт, сургалт, гэрээт ажил, автомашинтай холбоотой бусад зардлаас нийт 3,110.3 сая төгрөг хэмнэсэн байна.

Тайлант онд ам.долларын төгрөгтэй харьцах ханш чангарснаас 5,185.6 сая төгрөгийн ханшийн зөрүүний гарз, үндсэн хөрөнгө данснаас хассанаас 440.7 сая төгрөгийн гарз хүлээж, өмнөх онтой холбоотой 137.1 сая төгрөгийн зардал гарсан байна.

Тайлант онд 4,944.3 сая төгрөгийн орлогын албан татвар ногдуулж, нийт 135,480.2 цэвэр ашигтай ажилласан нь төлөвлөснөөс 11,467.3 сая төгрөгөөр илүү байна.

Компанийн 2022 оны цэвэр ашгаас төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг тогтоогоогүй.

ТӨБЗГ-т 2019 оны цэвэр ашгаас тогтоосон ногдол ашгийн дутуу 0.8 сая төгрөгийг тайлант онд төвлөрүүлсэн.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мүүрь Аудит ХХК-ийн баталгаажуулах үйлчилгээний менежер П.Нарантуяа, аудитор М.Гантуяа, аудиторын туслах М.Билгүүнжаргал, Г.Отгонзаяа нар гүйцэтгэж, хяналтыг Мэргэжлийн үйлчилгээ хариуцсан захирал У.Оюунаа, чанарын хяналтын менежер Н.Гэрэлчимэг тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэс Монгол ХХК нь 2022 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 04/76 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Өндөр” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 51,319.6 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 256.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор компани бүтэц орон тоог бууруулах, албан хэрэг хөтлөлт, хурал зөвлөгөөн, сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэх, зайлшгүй шаардлагатайгаас бусад засвар үйлчилгээ, хангамж, оффисын зардлыг бууруулах арга хэмжээ авсан байна .

Энэ хуулийн хүрээнд тэргүүн дэд, дэд захирал, зөвлөхийн орон тоог хассанаар 132.0 сая төгрөг, 3-6 сард түр сул зогсолт хийсэнтэй холбоотой 565.9 сая төгрөгийн цалингийн зардал хэмнэсэн. Хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд үйл ажиллагааны зардлаас нийт 2,135.0 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэс Монгол ХХК нь тайлант онд нийт 346,447.0 сая төгрөгийн 1,488 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 415,8 сая төгрөгийн 13 мэдээллийг ил тод байршуулаагүй, 2,961.5 сая төгрөгийн 2 мэдээллийг давхардуулан мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд мэдээллийг дутуу, давхардуулан мэдээлсэн зөрчилд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 21 дугаар тогтоолоор 6,894.3 сая төгрөгийн худалдан авалтын төлөвлөгөөг баталсан байна. Үүнээс 5 удаагийн худалдан авалтыг үнийн харьцуулалтын аргаар, 4 удаагийн худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтыг цахимаар хийж, 878.5 сая төгрөгийн худалдан авалт, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, төсөвлөснөөс 145.5 сая төгрөг хэмнэсэн байна.

Тайлант оны эцэст тендерийг үнэлж гэрээ байгуулах шатанд 1 худалдан авалт хүлээгдэж байгаа бөгөөд тайлант жил тендер сонгон шалгаруулалт зарласан боловч амжилтгүй болсон, оролцогч байхгүй, төлөвлөгөөт ажлууд хийгдсэний дараа зарлагдах шалтгаанаар хойшилсон нийт 10 худалдан авалтыг цуцалсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн худалдан авалтын үйл ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2022 оны 9 дүгээр сарын 30-наар тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 63,078.2 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 63,078.2 сая төгрөгийн алдааг залруулсан. Үүнд: өмнөх тайлант үед хамаарах хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг 15,676.9 сая төгрөгөөр илүү бүртгэснийг, урт хугацаат өр төлбөрийн хорогдуулгыг бүртгэлд тусгаагүй 46,849.3 сая төгрөг, хөрөнгө дутуу бүртгэсэн 15.2 сая төгрөг, хойшлогдсон татварын хөрөнгийг буруу тооцож бүртгэсэн 441.7 сая төгрөг, зардал буруу бүртгэсэн 82.6 сая төгрөг, орлого дутуу бүртгэсэн 12.5 сая төгрөгийн алдааг тус тус залруулсан байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/, СНАГ-2023/70/НА-СТА-ТӨА

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 84.3 хувь байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитаар өгсөн |                     | Биелэлт  |                      |             |
|-----------------|----------------------|---------------------|----------|----------------------|-------------|
|                 | Тоо                  | Дүн                 | Тоо      | Дүн                  | Хувь        |
| Акт             | 2                    | 1,587.3             | 2        | 1,587.3              | 100.0       |
| Албан шаардлага | 7                    | 27,907,056.7        | 4        | 27,839,209.2         | 78.4        |
| Зөвлөмж         | 4                    | 18,861,189.3        | 3        | 18,094,536.4         | 75.3        |
| <b>Нийт дүн</b> | <b>13</b>            | <b>46,769,833.3</b> | <b>9</b> | <b>459,935,332.9</b> | <b>84.3</b> |

Хэрэгжээгүй албан шаардлага:

1. ТУЗ-ийн тогтоолын дагуу 2019 онд гүйцэтгэх захирлыг Оксфордын их сургуулиас зохион байгуулсан сургалт семинарт оролцуулахаар 16.2 сая төгрөгийг шилжүүлсэн боловч сургалт зохион байгуулагдаагүй байна. Уг төлбөрийг гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан албан тушаалтнаас авах авлагаар бүртгэсэн ба Оксфордын их сургуульд сургалтын төлбөрийг буцаан авах хүсэлт илгээсэн боловч өнөөг хүртэл авлага барагдаагүй байна.

2. Компанийн ажилтнууд ажлаас чөлөөлөгдсөний улмаас өмнөх онд өгсөн 45.1 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг барагдуулах албан шаардлага биелэгдээгүй байна.

Хэрэгжээгүй зөвлөмж:

ТӨБЗГ-ын 2021.6.24-ний өдрийн 228 дугаар тогтоолоор тогтоосон, 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны 766.6 сая төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй, ногдол ашгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн анхаарал татсан дараах асуудлуудыг дараагийн аудитаар шалгахаар шийдвэрлэлээ. Үүнд:

Эрдэнэс Монгол ХХК нь менежментийн чадавхыг дээшлүүлэх төслийн хүрээнд, 2018 оны 11 сард БДО аудит ХХК, Гүрэн дээд сургуультай хамтран 2.3 сая ам долларын өртөгтэй зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан байна. Гэрээт ажлын гүйцэтгэлд хамтран оролцогч талууд 1.3 сая ам долларыг хүлээн авсан ба үлдэгдэл төлбөр болох 1.1 сая ам доллар, алданги 0.1 сая ам долларыг гаргуулахаар Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон улсын арбитра хандаж нэхэмжлэл гаргасан байна. Нэхэмжлэгчийн шаардлагад дурдсанаар хамтран оролцогч тал нь гэрээний үүргээ биелүүлсэн бөгөөд гүйцэтгэх удирдлагын удаа дараагийн өөрчлөлт болон асуудалд хойрго хандсанаас төслийг санхүүжүүлж байсан Азийн хөгжлийн банкнаас төлбөрөө авч чадаагүй гэж гомдол гаргаж, нэхэмжлэлийн шаардлагыг хангуулахыг хүссэн байна. Энэхүү нэхэмжлэлд хамаарах арбитрын хэргийг Эрдэнэс Монгол ХХК-ийн зүгээс гаргасан хүсэлтийн дагуу түр хойшлуулсан бөгөөд хэрвээ нэхэмжлэгчийн шаардлагыг хангах бол томоохон хэмжээний өр төлбөрийг барагдуулах үүрэг хүлээхээр байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 38,747.3 сая төгрөгийн алдаа<sup>2</sup> илэрснээс аудитын явцад 21,474.3 сая төгрөгийн алдааг залруулж, 17,273.0 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн. Үүнд:

Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 429 дүгээр тогтоолын дагуу охин компанид оруулсан хөрөнгө оруулалтыг Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-д эзэмшиж буй хувьцааны 21,353.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, гэрээний гүйцэтгэлд үндэслэн хайгуул үнэлгээний хөрөнгийг 111.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, үйл ажиллагааны зардлыг 9.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх залруулга тус тус хийсэн.

Аудитаар нийт 1,865.1 сая төгрөгийн зөрчил<sup>3</sup> илэрснээс, 16.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1,849.0 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 1,865.1 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 256.6 сая төгрөгөөс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 5 дугаар сарын 31-ний 21 дүгээр тогтоолоор нэг жолоочийн орон тоог баталсан байна. Эрдэнэс Монгол ХХК нь нэр бүхий 2 иргэнтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулан, жолоочоор ажиллуулж, 16.1 сая төгрөгийн цалин олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.1 “Улсын их хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

### 5.2 Албан шаардлага

1. Эрдэнэс Монгол ХХК нь 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны 766.7 сая төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 “Улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.5.1 “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1-д зааснаас бусад төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг,” заалт, ТӨБЗГ-ын 2021 оны 228 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төлөөлөн удирдах зөвлөлд тогтоолын үндэслэлийг дахин хянаж, ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэх.

2. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй ажилтантай холбоотой 61.3 сая төгрөгийн авлага, мөн 2019 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй Гашуунсухайт автозам ХХК-д олгосон санхүүжилтийн 1,000.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 5.1.3 “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6.4.1 “Төсвийг

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага барагдуулах албан шаардлага хүргүүлэх

3. Эрдэнэс Монгол ХХК нь гадаадын 7 улсаас мэдээлэл авах, туршлага судлах зорилготой бусад төрийн захиргааны байгууллагын 2 мэргэжилтний гадаад томилолтын зардалд 21.0 сая төгрөгийг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах, хуулийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэх

4.Тухай бүр гэрээг дүгнэж, үүрэг хариуцлагыг тодорхойлж, ажил гүйлгээг бүртгэлд тусгадаггүйгээс өмнөх онуудад үүссэн 23.3 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан, худалдан авсан 59.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг нэр төрөл бүрээр бүртгэлд тусгаагүй, гүйцэтгэх захирлын тушаалаар бүтцийн өөрчлөлтийн улмаас ажлаас чөлөөлөгдсөн 24, талууд харилцан тохиролцож, хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосон 2 ажилтан, нийт 26 хүнд 2-5 сарын үндсэн цалинтай тэнцэх 285.5 сая төгрөгийн төсөвлөгдөөгүй тэтгэмжийг олгосон нь нь дотоод хяналтыг оновчтой зохион байгуулж хэрэгжүүлээгүйгээс үүссэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1 “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”, Төсвийн тухай хуулийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах,” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах, хуулийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэх;

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1.Нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрдэнэс Монгол ХХК-ийн хөрөнгө оруулсан 3 хараат, 1 охин компани нь сүүлийн жилүүдэд идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд санхүүжилт олгодог төсөл хөтөлбөрүүдийг үр дүн тодорхойгүй байна. Уг төсөл хөтөлбөр, охин хараат компанид оруулсан 5,451.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтад үнэ цэний бууралт үүссэн боловч бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1 “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.1.Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт” гэж заасантай, СТОУС -9, Санхүүгийн хэрэглүүр, параграф 5.2.2 “аж ахуйн нэгж нь 4.1.2-р параграфын дагуу хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгөнд 4.1.2А параграфын дагуу 5.5-р хэсэг дэх үнэ цэний бууралтын шаардлагуудыг мөрдөнө.”, СТОУС-13 “Бодит үнэ цэний хэмжилт, параграф-5, 6 ба 7-р параграфт зааснаас бусад тохиолдолд бодит үнэ цэний хэмжилт, бодит үнэ цэний хэмжилтийн тодруулга хийхийг шаарддаг бол энэ стандартыг мөрдөнө” гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсөл хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж, цаашид хэрэгжүүлэх эсэхийг тодорхойлж, санхүүгийн хөрөнгөө удирдах, бизнесийн загвараа өөрчилсөн бол санхүүгийн хөрөнгийг дахин ангилах, санхүүгийн хөрөнгийн эрсдэл өгөөж, хяналтыг бусдад шилжүүлсэн, эрх үүрэг дуусгавар болсон гэж үзвэл холбогдох судалгаа шинжилгээ, тогтоол шийдвэрийг үндэслэн үл хүлээн зөвшөөрөх буюу данснаас хасах шаардлагатай.

## **2. Урт хугацаат өр төлбөртэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Эрдэнэс-1 бондын үлдэгдлийг Монголбанктai тулган баталгаажуулахад нэрлэсэн үнээр 88.0 сая төгрөгөөр илүү байна. Арилжааны банкуудтай байгуулсан “Иргэний тэтгэврийн зээлийн төлбөрийг үнэт цаасаар төлөх тухай” гэрээний үүргийг Монголбанк шилжүүлсэн авсан боловч Капитал банктai байгуулсан 166.0 сая төгрөгийн гэрээний өр төлбөрийг шилжүүлэн аваагүй байна. Уг гэрээтэй холбоотой бондын өөрчлөлтийг бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", СТОУС-9 Санхүүгийн хэрэглүүр параграф 3.1.1 "Аж ахуйн нэгж нь тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон үед санхүүгийн өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэнэ", параграф 3.2 "Аж ахуйн нэгж нь тухайн санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хугацаа дууссан эсвэл санхүүгийн хөрөнгийг шилжүүлсэн буюу эрсдэл өгөөжийг шилжүүлсэн бол үл хүлээн зөвшөөрнө" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Монголбанк болон Капитал банк дахь банкны эрх хүлээн авагчтай тооцоо нийлж, бондын өр төлбөрийг баталгаажуулах, гэрээнд заасан бондын тоо хэмжээний өөрчлөлтийг зохих баримтыг үндэслэн бүртгэлд тусгах, бондын өөрчлөлтийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгүүлэх, Монголбанк болон арилжааны банкуудын хооронд хийсэн үнэт цаас худалдах, худалдан авах тухай гэрээг үндэслэн Монголбанкинд төлөх бондын өр төлбөрийг бүртгэж, зөрүүг залруулах зөвлөмж өгөв.

## **2. Хөрөнгийн үнэ цэний бууралттай холбоотой**

**Илрүүлэлт:** Эрдэнэс Монгол ХХК-ийн үндсэн хөрөнгийн барилга байгууламж дансанд бүртгэлтэй 11,655.9 сая төгрөгийн дансны үнэ бүхий Гашуунсухайт боомтын дэд бүтцийн байгууламжаас боомтын хашаанд байсан 3 сэндвичэн барилгыг 2019 онд буулгасан байна. Жилийн эцсийн тооллогын комисс уг сэндвичэн барилгын шинж чанар, ашиглагдах байдлыг тодорхойлж, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх санал оруулсан боловч шийдвэрлээгүй байна.

Энэ нь НББОУС 16-Үндсэн хөрөнгө, параграф 63, 67 "Үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг НББОУС-36 Хөрөнгийн үнэ цэний бууралт стандартын дагуу тодорхойлж, ирээдүйд дансны үнийг нөхөхгүй буюу эдийн засгийн үр өгөөжгүй болсон үндсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө." гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газраас хийсэн мониторингийн үр дүнг Гүйцэтгэх удирдлага, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, буулгасан барилгын дансны үнэ, цаашид ашиглагдах байдал зэргийг тодорхойлж, үл үндэслэлтэй тооцоолол, холбогдох байгууллага, удирдлагын зөвшөөрлөөр данс бүртгэлээс хасах, үнэ цэний бууралтыг бүртгэх арга хэмжээ авах.

### 3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансанд оруулбал зохих 13 мэдээллийг ил тод байршуулаагүй, 2 мэдээллийг давхардуулсан мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансанд бүх мэдээллийг цаг хугацаанд нь давхардуулахгүй, орхигдуулахгүй мэдээлэх, оруулсан мэдээлэл үнэн зөв эсэхийг эргэн хянадаг байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга                                                                                                                                                                                | Нийт алдаа |              | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |     | Үүнээс     |              |              |              | Зөвлөмж |              |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|--------------|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|--------------|--------------|--------------|---------|--------------|
|                                                                                                                                                                                                  |            |              |                                   |     |                          |     | Залруулсан |              | Залруулаагүй |              |         |              |
|                                                                                                                                                                                                  | Тоо        | Дүн          | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн | Тоо        | Дүн          | Тоо          | Дүн          | Тоо     | Дүн          |
| Засгийн газрын 2022.11.30-ны өдрийн 429 дүгээр тогтоолоор Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн хөрөнгө оруулалтыг бүртгээгүй байна.                                                                    | 1          | 21,353,312.0 |                                   |     |                          |     | 1          | 21,353,312.0 |              |              |         |              |
| Эрүүл мэндийн даатгалын 2022 онд хүлээн зөвшөөрөх зардлын дүнг дутуу бүртгэсэн.                                                                                                                  | 1          | 9,800.0      |                                   |     |                          |     | 1          | 9,800.0      |              |              |         |              |
| Хотын цамхаг ХХК-тай хийсэн ЭМГЛ -49/АГГ-08/20200831 дугаар гэрээний хэрэгжилтийг тайлант онд дүгнэж, гэрээ дүгнэсэн акт үйлдэж үлдэгдэл төлбөрийг шилжүүлсэн боловч хөрөнгөөр бүртгээгүй байна. | 1          | 111,159.8    |                                   |     |                          |     | 1          | 111,159.8    |              |              |         |              |
| Бондын өр төлбөрийг Монгол банкттай тулган баталгаажуулахад Капитал банкттай байгуулсан гэрээний дүнгээр зөрсөн байна.                                                                           | 1          | 166,000.0    |                                   |     |                          |     |            |              | 1            | 166,000.0    | 1       | 166,000.0    |
| ЭМГЛ ХХК-ийн харьяа 2 төсөл хөтөлбөр, 4 хараат, охин компаниуд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн авлагад үнэ цэний бууралт үүссэнийг бүртгэлд тусгаагүй.                                  | 1          | 5,451,082.0  |                                   |     |                          |     |            |              | 1            | 5,451,082.0  | 1       | 5,451,082.0  |
| Гашуунсухайт дахь боомтын дэд бүтцийн байгууламжаас 3 барилгыг буулгаж, хураасан боловч цаашид хэрхэх талаар шийдвэрлээгүй байна.                                                                | 1          | 11,655,951.0 |                                   |     |                          |     |            |              | 1            | 11,655,951.0 | 1       | 11,655,951.0 |
| Дүн                                                                                                                                                                                              | 6          | 38,747,305.8 | -                                 | -   | -                        | -   | 3          | 21,474,272.8 | 3            | 17,273,033.0 | 3       | 17,273,033.0 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | Нийт зөрчил |             | Үүнээс        |          |                 |             |         |     |                                      |                     |                                                 |     |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-------------|---------------|----------|-----------------|-------------|---------|-----|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|-----|
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |             |             | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |             | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | Тоо         | Дүн         | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн         | Тоо     | Дүн | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                             | Дүн |
| ТӨБЗГ нь 2021 оны 228 дугаар тогтоолоор 2020 оны цэвэр ашгаас улсын төсөвт төвлөрүүлэхээр тогтоосон 766.6 сая төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлээгүй байна.                                                                                                                                                                                                                                                                                                                           | 1           | 766,652.9   |               |          | 1               | 766,652.9   |         |     |                                      |                     |                                                 |     |
| Байгууллагын бүтцийн өөрчлөлтөөр 1 жолооч ажиллах орон тоо батлагдсан боловч 2022 оны 5 дугаар сараас 10 сар хүртэл хөлсөөр ажиллах гэрээ байгуулан 2 жолооч нэмж ажиллуулсан байна.                                                                                                                                                                                                                                                                                                  | 1           | 16,155.8    | 1             | 16,155.8 |                 |             |         |     |                                      |                     |                                                 |     |
| Эрдэнэс Монгол ХХК нь гадаадын 7 улсаас мэдээлэл авах, туршлага судлах зорилготой Бусад төрийн захиргааны байгууллагын 2 мэргэжилтний гадаад томилолтын зардалд 21,000,000.0 төгрөгийг шилжүүлсэн байна.                                                                                                                                                                                                                                                                              | 1           | 21,000.0    |               |          | 1               | 21,000.0    |         |     |                                      |                     |                                                 |     |
| Өмнөх оны аудитаар өгсөн ажилтнаас авах авлагыг барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          | 1           | 61,347.6    |               |          | 1               | 61,347.6    |         |     |                                      |                     |                                                 |     |
| Тухай бүр гэрээг дүгнэж, үүрэг хариуцлагыг тодорхойлж, ажил гүйлгээг бүртгэлд тусгадаггүйгээс өмнөх онуудад үүссэн 23.3 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан, худалдан авсан 59.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг нэр төрөл бүрээр бүртгэлд тусгаагүй, гүйцэтгэх захирлын тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн 26 хүнд 2-5 сарын үндсэн цалинтай тэнцэх 285.5 сая төгрөгийн төсөвлөгдөөгүй тэтгэмжийг олгосон нь дотоод хяналтыг оновчтой зохион байгуулж хэрэгжүүлээгүйгээс үүссэн байна. | 1           | -           |               |          | 1               | -           |         |     |                                      |                     |                                                 |     |
| 2019 онд үүссэн Гашуунсухайт Автозам ХХК-аас авах 1.0 тэрбум төгрөгийн авлага барагдаагүй байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | 1           | 1,000,000.0 |               |          | 1               | 1,000,000.0 |         |     |                                      |                     |                                                 |     |
| Дүн                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   | 6           | 1,865,156.3 | 1             | 16,155.8 | 5               | 1,849,000.5 | -       | -   | -                                    | -                   | -                                               | -   |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Д.д                                                      | Зөрчлийн товч утга                                                                                               | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |
|----------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|                                                          |                                                                                                                  |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|                                                          |                                                                                                                  | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |                                                                                                                  |             |     |               |     |                 |     |         |     |
| 1                                                        | Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1488 мэдээллээс 13 мэдээллийг байршуулаагүй байна. | 1           | -   |               |     |                 |     |         |     |
|                                                          | Дүн                                                                                                              | 1           | -   |               |     |                 |     |         |     |